

БАТЛАВ:

НИЙСЛЭЛИЙН ЗАМЫН ХӨГЖЛИЙН
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Г.БАЯРСАЙХАН

АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖ, АВТО ЗОГСООЛЫН ЗУРАГ ТӨСӨЛ
БОЛОВСРУУЛАХ ТЕХНИКИЙН ДААЛГАВАР

Дугаар: 240707125

2024.1.4

1	Зураг төсөл боловсруулах үндэслэл	- Нийслэлийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн А/1486 дугаартай захирамж - Нийслэлийн худалдан авах ажиллагааны газрын 2024 оны 1 дүгээр сарын 2-ны 3/6 дугаартай албан тоот.
2	Байршил	Соболева гудамжны 4 замын уулзвараас “Сэнгүүр горхи хотхон” хүртэл
3	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр	Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр
4	Авто замын техникийн ангилал, замын зэрэг	Төслийн байршлаас хамааруулан сонгоно.
5	Газрын бартаалаг, төвөгшил	Трасс сонголтын үеийн болон замын төсөллөлтийн төвөгшлийг БНБД-ээс харах
6	Замын хучилтын хийц	Хучилтын бүтээцийг тооцоогоор үндэслэнэ.
7	Зураг төсөл зохиох үе шат, хугацаа	1 үе шаттай 2024 он
8	Зураг төслийн байгууллага	Авто зам, замын байгууламжийн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөлтэй байгууллага.
9	Захиалагч байгууллага	Нийслэлийн замын хөгжлийн газар
10	Зураг төслийн иж бүрдэл	Авто зам, замын байгууламжийн техникийн зураг Авто замын төсөв /магадлалаар оруулах/
11.	Онцгой нөхцөл:	
		<p>➤ Авто замын зургийг Монгол улсад мөрдөж буй “Авто зам төсөллөх” ЗЗБНБД 22-004-2016, “Авто зам, гүүрийн зураг төсөл, хайгуулын ажлын жишиг үнэ” БД81-104-02, “Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм” БНБД 30.01.04, Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн нормаль” БД31.101.04, “Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар” MNS 6056-2009, Сургуулийн бүс техникийн шаардлага MNS6444 “Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам, техникийн шаардлага” MNS 5682:2006, “Авто замын гүүр ба хоолой төсөллөх” БНБД 32-02-12, “Явган хүний зам, талбай төсөллөлт, техникийн шаардлага” MNS 6808:2019, , “Авто зам, замын байгууламж. Унадаг дугуйн замыг төлөвлөхөд тавих ерөнхий шаардлага” MNS 5683:2022, “Авто зам, замын байгууламж болон инженерийн шугам сүлжээний ажлын төсөвт өртгийг хүчин төгөлдөр мөрдөгдөж буй төсвийн жишиг нормын дагуу тооцох, магадлалаар оруулан баталгаажуулах, ЗТХ-ийн Сайдын 2018 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн 168 дугаар тушаалаар батлагдсан “Авто зам, замын байгууламжийн зураг төсөлд магадлал хийж, дүгнэлт гаргах журам” болон бусад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох норм дүрмүүдийг үндэслэх</p> <p>➤ Геодезийн хэмжилт зураглалын ажлыг улсын сүлжээний цэгүүдэд тулгуурлан хийх, зам барилгын суурь бэлтгэл ажлын хүрээнд хийгдэх тулгуур цэг байгуулах, замын төлөвлөлтийн</p>

дагуу өндрийн болон байрлалын хэмжилт хийж баталгаажуулж газрын хар өндрийг тодорхойлох

- Авто замын зураг төслийг Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон бусад төлөвлөлт, засвар шинэчлэлтийн трасстай уялдуулан төлөвлөх.
- Трасс сонголтыг газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлт, инженерийн шугам сүлжээ, одоо байгаа барилга байгууламж, хэтийн хөдөлгөөний эрчмийг анхаарч үзэх
- Авто замын үндсэн элементүүд болох авто замын зорчих хэсэг, явган хүний зам, унадаг дугуйн зам /төслөөр/, явган хүний гарц /нэг болон хоёр түвшин гарцыг төслөөр/ төлөвлөх. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчин бүрдүүлэх зорилгоор зам талбайн болон хөдөлгөөн зохион байгуулалтын арга хэмжээ, тоноглол, замын холбогдох байгууламжуудыг тусгасан байх.
- **Шаардлагатай тохиолдолд гэрэлтүүлэг төлөвлөх.**
- Зураг төслийг дараах масштабтайгаар боловсруулна. Үүнд:

Дэвсгэр зураг		1:500
Дагуу огтлол	Хэвтээ	1:1000
	Босоо	1:100
Хөндлөн огтлол		1:100
Уулзвар огтлолцол		1:500
Бүтээц		1:20

- Нийслэлийн Хот байгуулалт хөгжлийн газар, Нийслэлийн Замын хөгжлийн газар, Нийслэлийн Газар Зохион Байгуулалтын Алба, Нийслэлийн хот тохижилтын газар ОНӨААТҮГ-тай тус тус зөвшилцөх,
- Авто замын техникийн зураг төсөлд замын байгуулалт, зай хэмжээ, хөдөлгөөн зохион байгуулалтыг төсөллөж, цэгүүдийн координат, зам барилгын ажлын тоо хэмжээг оруулсан байна.
- Зам барилгын ажлын гүйцэтгэгч нь холбогдох шугам сүлжээний байгууллагаас тодруулга авах
- Нийслэлийн Замын хөгжлийн газрын авто зам, замын байгууламжийн зураг төсөл боловсруулах ажлын даалгаврын дагуу зураг төслийг боловсруулах
- Тухайн замын үндсэн элементүүдийг (авто зам, зогсоол, хөдөлгөөн зохион байгуулалтын тэмдэг тэмдэглэгээ) Layer тус бүрээр нь салгаж Autocad файлаар өгөх.

Авто замын техникийн зураг төсвийг эх хувь 1ш, хуулбар хувь -1ш / хуулбар хувийг өнгөтөөр хувилж авчрах/ цахим хэлбэрээр / DWG болон PDF / архивт, орон зайн болон орон зайн бус мэдээллийг тоон хэлбэрээр мэдээллийн санд батлагдсан загварын дагуу хүлээлгэж өгөх.

ХЯНАСАН:


НЗХГ-ын БТХ-ийн дарга



В.Мягмар

БОЛОВСРУУЛСАН:

БТХ-ийн мэргэжилтэн



Г.Ундрэм

НИЙСЛЭЛИЙН ЗАМЫН
ХӨГЖЛИЙН ГАЗАР

Газрын байршил
БЗД 41 дүгээр хороо

Газрын зориулалт
Авто зам



Таних тэмдэг:

 Төлөвлөж буй байршил

Хянасан:

НЗХГ-ын БТХ-ийн дарга / В.Мягмар /

Боловсруулсан:

НЗХГ-ын БТХ-ийн мэргэжилтэн..... / Г.Ундрал /